



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/04

Өвт

Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөл,
комиссыг шинэчлэн байгуулах тухай.


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбогдуулан хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хууран авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах үйл ажиллагааг шийдвэрлэх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, үнэлгээний, устгалын, худалдан борлуулах комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журмыг хэрэгжүүлж, орлогыг орон нутгийн төсөвт тухай бүр төвлөрүүлж, тайлан мэдээг улирал бүр Засаг даргад мэдээлж, тайланг хагас, бүтэн жилээр гарган Хархорин сум дахь Сум дундын Прокурорын газарт хүргүүлж ажиллахыг (Нарийн бичгийн дарга)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын "Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөл, комиссыг шинэчлэн байгуулах тухай" 2019 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн А/115 захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

057101007

C:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

Сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн
А/ОХ дугаар захирамж 1 дүгээр хавсралт

**СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН ШИНЭЧИЛСЭН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга: Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Сум дундын Ойн ангийн дарга


Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Цагдаагийн тасгийн дарга

Нарийн бичгийн дарга: Санхүүгийн албаны дарга

Сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн
А/04: дугаар захирамж 2 дугаар хавсралт

ҮНЭЛГЭЭНИЙ КОМИСС



Комиссын дарга Санхүүгийн албаны дарга
Гишүүд: Сум Дундын Ойн ангийн дарга
Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

ХУДАЛДАН БОРЛУУЛАХ КОМИСС

Комиссын дарга: Засаг даргын орлогч
Гишүүд: Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч
Засаг даргын Тамгын газрын Нярав

УСТГАЛЫН КОМИСС

Комиссын дарга: Цагдаагийн тасгийн дарга
Гишүүд: Хөдөө аж ахуйн тасгийн дарга
Татварын улсын байцаагч